

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.28 № 2/96
танай _____-ны № _____-т

БУЯНТ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Т.ЭНХТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буюнт сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Шууд худалдан авалтаар тендерээр нийлүүлж байгаа эм, эмийн хэрэгслээс илүү үнээр 3,443.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн;
- Насжилт өндөртэй эм, эмийн хэрэгслийн үлдэгдэл ихтэй, шууд худалдан авалтаар эм, эмийн хэрэгсэл худалдан авснаар 40,695.4 мянган төгрөгийн эмийн өр үүссэн;
- Шатахууны зардалд 3,758.8 мянган төгрөг анхан шатны баримт хангалтгүй, замын хуудсаар баталгаажуулаагүй, дотоод хяналт болон бүртгэлээр тавих хяналт сул;

- Өмнөх оны зөвлөмжөөр өгөгдсөн зөвлөмж хэрэгжээгүй, хөрөнгийг ангилан зөв бүртгээгүй 3,038.0 мянган төгрөгийн зөрчил ;
- Цалингийн зардлаас зардлаас 10,554.6 мянган төгрөгийг урсгал зардал болох эмийн үнэ төлж зориулалт бус зарцуулсан.

Асуудлыг онцолсон хэсэг

Улс, орон нутгийн төсвөөр 179,479.1 мянган төгрөгийн өртөгтэй эмнэлгийн шинэ машин, 113,911.0 сая төгрөгийн өртөгтэй тавилга, тоног төхөөрөмжөөр хангагдаж иргэдэд хүрэх эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжтэй болох нөхцөл бүрдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг 8 зорилт 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89,5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан сумын Засаг даргаар баталгаажуулаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>190,936,494.96</u>	<u>199,626,769.27</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	56,813,624.08	135,299.07
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	56,813,624.08	135,299.07
3121	Төгрөг	56,813,624.08	135,299.07
31211	Төрийн сангийн харилцах	56,813,624.08	135,299.07
33	АВЛАГА	10,069,789.00	104,994,884.94
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	187,500.00	187,500.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	9,882,289.00	104,807,384.94
35	БАРАА МАТЕРИАЛ	124,053,081.88	94,496,585.26
351	Түүхий эд материал	53,575,054.78	22,508,199.87
35110	Тусгай зориулалттай материал	5,641,390.17	7,829,340.17
35130	Эм боох материал	47,933,664.61	14,678,859.70
354	Хангамжийн материал	70,478,027.10	71,988,385.39
35410	Бичиг хэргийн материал	975,640.00	1,232,140.00
35420	Аж ахуйн материал	55,595,911.00	65,155,595.40
35430	Сэлбэг хэрэгсэл	175,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	3,424,020.00	-
35460	Хүнсний материал	9,553,456.10	4,846,649.99
35470	Бусад хангамжийн материал	754,000.00	754,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>538,648,360.87</u>	<u>823,374,370.17</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	538,648,360.87	823,374,370.17
392	Биет хөрөнгө	512,642,798.26	797,374,370.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	465,129,286.00	465,129,286.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,921,593.07)	(88,370,934.55)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,979,720.00	267,879,086.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(55,690,138.19)	(66,515,137.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	213,877,208.17	320,590,089.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(131,682,989.31)	(156,215,001.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,357,884.90	30,720,406.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,406,580.24)	(14,294,266.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	38,450,842.00
393	Биет бус хөрөнгө	26,005,562.61	26,000,000.00
39301	Програм хангамж	732,000.00	732,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(726,437.39)	(732,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	26,000,000.00	26,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>729,584,855.83</u>	<u>1,001,573,113.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,910,610.00</u>	<u>31,188,985.44</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,910,610.00	31,188,985.44
413	Өглөг	3,910,610.00	31,188,985.44
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	6,964,865.94
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,910,610.00	24,224,119.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>725,674,245.83</u>	<u>991,812,154.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	725,674,245.83	991,812,15.00

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	176,131,310.00	176,131,310.00
51101	Өмч: - төрийн	176,131,310.00	176,131,310.00
512	Хуримтлагдсан үр дүн	301,153,151.75	567,291,059.92
51210	Өмнөх үеийн үр дүн	301,153,151.75	301,153,151.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	266,137,908.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	248,389,784.08	248,389,784.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	729,584,855.83	1,023,001,139.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	874,509,334.77	1,318,571,772.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,346,311,573.71
120	Нийтлэг татварын бус орлого	87,883,455.91	335,112,731.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	87,510,455.91	335,112,731.40
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	87,510,455.91	335,112,731.40
120009	Бусад орлого	373,000.00	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	22,586,000.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	22,586,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	696,625,878.86	1,011,198,841.94
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,104,236.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,104,236.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	30,521,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	30,521,600.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		979,573,006.31
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	674,039,878.86	979,573,006.31
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	653,926,167.87	1,080,173,665.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	653,926,167.87	1,080,173,665.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	653,563,685.02	1,079,991,976.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,054,578.45	703,363,612.21
210101	Үндсэн цалин	250,045,180.38	400,593,931.15
210102	Нэмэгдэл	107,103,807.97	212,110,322.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,632,005.28	31,311,000.00
210104	Урамшуулал	33,095,809.00	37,510,770.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,177,775.82	21,837,588.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,171,924.73	87,801,201.08
210201	Тэтгэврийн даатгал	38,162,253.36	59,678,552.14
210202	Тэтгэмжийн даатгал	3,771,259.53	7,021,006.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,017,007.61	3,971,375.74
210204	Ажилгүйдлийн даатгал	747,400.05	3,426,053.45
210205	Эрүүл мэндийн даатгал	7,474,004.18	13,704,213.62

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,980,347.15	31,165,781.17
210301	Гэрэл, цахилгаан	4,360,137.15	5,395,561.17
210302	Түлш, халаалт	13,370,210.00	25,770,220.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	25,865,686.14	27,700,936.00
210401	Бичиг хэрэг	2,509,000.00	2,375,900.00
210402	Тээвэр, шатахуун	18,923,000.00	15,268,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,479,307.14	2,765,348.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	1,343,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,116,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,834,379.00	4,831,838.00
2105	Нормативт зардал	74,723,233.55	149,418,456.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,212,449.20	135,214,050.45
210502	Хоол, хүнс	10,510,784.35	14,204,406.11
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,253,000.00	5,276,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,927,500.00	3,509,900.00
210604	Урсгал засвар	325,500.00	1,766,850.00
2107	Томилолт, зочны зардал	1,192,000.00	4,356,000.00
210702	Дотоод албан томилолт	1,192,000.00	4,356,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,384,015.00	5,878,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,209,530.00	5,817,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	141,485.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	28,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,938,900.00	59,239,437.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	666,474.00	7,089,729.23
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,272,426.00	52,149,707.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	362,482.85	181,688.83
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	362,482.85	181,688.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	362,482.85	181,688.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	130,583,166.40	266,137,908.17
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	130,583,166.40	266,137,908.17

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,131,310.00	248,389,784.08	301,153,151.75	725,674,245.83
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	176,131,310.00	248,389,784.08	301,153,151.75	725,674,245.83
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	176,131,310.00	248,389,784.08	301,153,151.75	725,674,245.83

D08	Тайлант үеийн үр дүн	-	-	266,137,908.17	266,137,908.17
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,131,310.00	248,389,784.08	567,291,059.92	991,812,154.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	687,116,589.86	916,273,746.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	687,116,589.86	916,273,746.37
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,104,236.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,104,236.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,959,000.00	30,521,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,959,000.00	30,521,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	664,157,589.86	884,647,910.37
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	664,157,589.86	884,647,910.37
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	642,497,346.32	972,952,071.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	642,497,346.32	972,952,071.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	642,134,863.47	972,770,382.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	421,595,968.43	730,926,795.85
210101	Үндсэн цалин	240,110,244.91	336,405,363.51
210102	Нэмэгдэл	117,507,809.22	283,277,938.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,161,361.35	31,240,614.59
210104	Урамшуулал	40,419,078.48	62,658,548.16
210105	Гэрээт ажлын хөлс	18,397,474.47	17,344,330.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,690,375.75	61,568,229.49
210201	Тэтгэврийн даатгал	33,840,705.49	38,438,244.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,981,259.53	6,574,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,437,007.46	2,422,299.69
210204	Ажилгүйдлийн даатгал	789,400.05	2,410,239.80
210205	Эрүүл мэндийн даатгал	7,642,003.22	11,723,046.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,393,567.15	27,827,561.17
210301	Гэрэл, цахилгаан	3,575,454.19	5,395,561.17
210302	Түлш, халаалт	16,818,112.96	22,432,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,044,107.14	27,161,998.00
210401	Бичиг хэрэг	2,076,000.00	2,887,400.00
210402	Тээвэр, шатахуун	19,073,800.00	15,132,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,479,307.14	2,765,348.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,905,000.00	1,156,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,510,000.00	5,360,500.00
2105	Нормативт зардал	97,299,588.00	70,864,991.04

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,802,100.00	58,829,291.04
210502	Хоол, хүнс	15,997,488.00	10,775,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,260,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,844,650.00	36,010,830.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,981,700.00	23,052,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	33,000.00	
210604	Урсгал засвар	1,829,950.00	12,958,030.00
2107	Томилолт, зочны зардал	1,192,000.00	1,040,000.00
210702	Дотоод албан томилолт	1,192,000.00	1,040,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,850,415.00	5,878,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,675,930.00	5,817,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	58,485.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	83,000.00	28,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,224,192.00	11,491,777.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,224,192.00	11,491,777.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	362,482.85	181,688.83
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	181,688.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	181,688.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>44,619,243.54</u>	<u>(56,678,325.01)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	44,619,243.54	(56,678,325.01)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,194,380.54	56,813,624.08
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	56,813,624.08	135,299.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,070,869,700.00	961,783,857.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,070,869,700.00	961,783,857.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,070,869,700.00	961,783,857.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	726,119,500.00	730,926,795.85
210101	Үндсэн цалин	353,490,400.00	336,405,363.51
210102	Нэмэгдэл	289,656,100.00	283,277,938.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,392,000.00	31,240,614.59
210104	Урамшуулал	53,981,000.00	62,658,548.16
210105	Гэрээт ажлын хөлс	21,600,000.00	17,344,330.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,467,600.00	61,568,229.49
210201	Тэтгэврийн даатгал	63,558,000.00	38,438,244.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,477,400.00	6,574,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,738,700.00	2,422,299.69
210204	Ажилгүйдлийн даатгал	3,738,700.00	2,410,239.80

210205	Эрүүл мэндийн даатгал	14,954,800.00	11,723,046.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,521,600.00	27,827,561.17
210301	Гэрэл, цахилгаан	6,800,000.00	5,395,561.17
210302	Түлш, халаалт	23,721,600.00	22,432,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,554,000.00	27,161,998.00
210401	Бичиг хэрэг	10,000,000.00	2,887,400.00
210402	Тээвэр, шатахуун	25,554,000.00	15,132,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	2,765,348.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	1,156,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000.00	5,220,500.00
2105	Нормативт зардал	89,544,000.00	70,864,991.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,805,600.00	58,829,291.04
210502	Хоол, хүнс	15,238,400.00	10,775,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,000.00	1,260,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,739,700.00	30,517,567.23
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,257,400.00	23,052,800.00
210604	Урсгал засвар	18,482,300.00	7,464,767.23
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.00	1,040,000.00
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	1,040,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,060,000.00	5,878,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,250,000.00	5,817,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	28,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	690,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,363,300.00	5,998,514.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,363,300.00	5,998,514.23
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,070,869,700.00	905,105,532.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,521,600.00	30,339,911.00
132001	Орон нутгийн төсвөөс	30,521,600.00	30,339,911.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,040,348,100.00	874,765,621.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,070,869,700.00	874,765,621.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		56,813,624.08
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		135,299.07

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 154,908.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 92,999.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд зөрүүтэй илэрхийлэгдэж тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал, батламж мэдээдлийг хангаагүй байгааг үр дүнгийн тайланд орлого буруу илэрхийлсэн 78,793.0 мянган төгрөг,
- Санхүүгийн байдлын тайланд хасах тэмдэгтэй авлага тусгасан 3,038.0 мянган төгрөг,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилт буруу илэрхийлсэн 11,168.2 мянган төгрөгийн залруулга хийсэн

Аудитаар нийт залруулагдаагүй мянган төгрөгийн 61,908.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,443.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 46,556.7 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд 1 албан шаардлага, 11,908.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн. Нийт зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: ЭМГ-аас тендер нэгдсэн журмаар зарлаж тендерээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэг бүрийн үнийг тогтоож өгсөн бөгөөд тендерийн гэрээний үнийн дүнгээс өндөр үнээр шууд гэрээ байгуулан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан 3.4 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

5.2. Албан шаардлага

Илрүүлэлт: Эм, эмийн хэрэгслийн зардал болох 36,0 сая төгрөгийн эмийг шууд гэрээ байгуулан худалдан авснаар эмийн их хэмжээний өр үүсэх нөхцөл бүрдсэн зөрчил илэрлээ.

Илрүүлэлт: Цалингийн зардлаас урсгал зардал болох эмийн үнэ төлж зориулалт бус зарцуулж цалингийн ашгийн өглөг их хэмжээгээр үүссэн нь санхүүгийн албаны дарга болон төрийн сангийн мэргэжилтний дотоод хяналт сул байгаа 10,5 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16-р зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичсэн

5.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Бараа материалын зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: Үнэ төлбөргүй орлогоор авсан 6 нэр төрлийн 4,7 сая төгрөгийн насжилт өндөртэй эм, эмийн хэрэгслийн үлдэгдэлтэй байгаа зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 16-р зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан насжилт өндөртэй эм, эмийн хэрэгслийг шийдвэрлэж дотоод хяналтыг сайжруулах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3.2 Шатахуун зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: Шатахууны тооцоо хангалтгүй, замын хуудасгүй дотоод ажлаар гэж их хэмжээгээр шатахуун зарлагдсан, өвчтөнийг ар гэрийн машинаар зөөсөн анхан шатны баримт байхгүй 3.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.3.3 Өглөгтэй холбоотой

Илрүүлэлт: Томилолтын өглөг баталгаажгаагүй нотлох баримтгүй өглөг тусгасан 3,4 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Буянт ЭМТ	Тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал, батламж мэдэгдлийг хангаагүй, үр дүнгийн тайланд орлого буруу илэрхийлсэн	1	78,790.0			1	78,790.0	1	78,790.0				
	Санхүүгийн байдлын тайланд хасах тэмдэгтэй авлага тусгасан	1	3,038.0			1	3,038.0	1	3,038.0				
	Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилт буруу илэрхийлсэн	1	11,168.2	1	11,168.2			1	11,168.2				
Нийт дүн		3	92,996.2	1	11,168.2	2	81,828.0	3	92,996.2				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Буянт ЭМТ	Шууд худалдан авалтаар тендерээр нийлүүлж байгаа эм, эмийн хэрэгслээс илүү үнээр авсан	1	3,443.9	1	3,443.9				
	Цалингийн зардлаас зардлаас урсгал зардал болох эмийн үнэ төлж зориулалт бус зарцуулсан, цалингийн ашгийн өглөг их хэмжээгээр үүссэн, төрийн сангийн мэргэжилтний хяналт сул,	1	10,554.6			1	10,554.6		
	Эм, эмийн хэрэгслийн зардал болох 36.0 сая төгрөгийн эмийг ерөнхий болон шууд гэрээ байгуулан худалдан авснаар эмийн өр үүсэх нөхцөл бүрдсэн байна		36,002.2				36,002.2		
	Шатахууны тооцоо хангалтгүй, замын хуудасгүй дотоод ажлаар гэж их хэмжээгээр шатахуун зарлагдсан ,	1	3,758.8					1	3,758.8
	Эм, эмийн хэрэгсэл болох 12 нэр төрлийн 34.5 мянган ширхэг 4.6 сая төгрөгийн насжилт өндөртэй эмийн үлдэгдэлтэй	1	4,693.2					1	4,693.2
	Томилолтын өглөг баталгаажаагүй нотлох баримтгүй өглөг тусгасан	1	3,456.0					1	3,456.0
	Дүн	5	61,908.7	1	3,443.9	1	46,556.8	3	11,908.0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Х.Болдбаатар* **Х.БОЛДБААТАР** 2025.02.25

АУДИТЫН МЕНЕЖЕР *А.Цэцэгсүрэн* **А.ЦЭЦЭГСҮРЭН** 2025.02.25

БЭЛТГЭСЭН:

“ЦАХИМ АКТИВ АУДИТ ХХК” -НЫ АУДИТОР **Д.БАЛЖИННЯМ** 2025.02.25

ХОА-2025/071/НА-СТА-ТШЗ